

**БОГД ХААНТ МОНГОЛ УЛС, БНМАУ-ААС ГЕРМАНТАЙ  
АЛБАН ЁСНЫ ХАРИЛЦАА ТОГТООХ ГЭСЭН АНХНЫ  
ОРОДЛОГУУД БА ГЕРМАНД АНХ МОНГОЛ ИРГЭД  
СУРГАЖ ЭХЭЛСЭН НЬ**

*Р.Жамц\**

Монгол-Германы харилцаа нь өнө эртнээс улбаатайгаас гадна хоёр ард түмэн уг харилцааг бий болгох талаар аль аль нь тэмүүлж иржээ.

Монголчууд ч гэсэн Германы соёл, шинжлэх ухаанаас суралцах, худалдаа, эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг ахиулах, өөрийн орныхоо тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэхэд Германы талын дэмжлэгийг олох талаар өөрсдийн талаас эрмэлзэж ирсэн түүхтэй. Монголын түүхээс авч үзвэл ХХ зууны эхээр буюу 1911 онд Монгол улс тусгаар тогтнолоо зарлаж гадаад улсуудаар хүлээн зөвшөөрүүлэх үйл ажиллагааг дипломат шугамаар явуулж эхлэх үеэс Монгол нь Германы дэмжлэгийг хайх болсон юм.

Ер нь Германтай харилцаа тогтоох эрмэлзлэл 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний дараа ч, 1921 оны ардын хувьсгалын жилүүдэд ч өрнөж байжээ. Энэ үед Чин ван Ханддорж, Сайн ноён хан Намнансүрэн зэрэг тусгаар тогтнолын зүтгэлтнүүд Орос улсын Санкт Петербурgt удаа дараа очиж гадаадын элчин сайдуудтай уулзахыг эрмэлзсэн ч, тэдний хичээл зүтгэл нь биелээгүй түүхтэй.

1926 онд МАХН-ын дарга Ц.Дамбадорж, НТХ-ны нарийн бичгийн дарга Н.Жадамбаа нар 30 ам.долларын зардалтайгаар 3 сар Герман, Франц зэрэг орнуудаар явж тэдгээр улсуудтай хэлхээ холбоо тогтоожээ. Тэдний энэ удаагийн аялал нь Судар бичгийн хүрээлэнгийн шугамаар Монгол судлал хөгжиж буй гадаадын зарим улс, их сургууль, хүрээлэнтэй холбоо тогтоох гэсэн утга бүхий томилолт байв. Тэд Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж байсан Германы “Остваг” пүүсийн нөхөд, Москвад элчин Д.Данзантай зөвлөлдөж байжээ. Аялалынхаа явцад Берлин, Лейпцигийн Конрадын коллежийн Зүүн Азийн салбарын эрхлэгч нэрт монголч эрдэмтэн, профессор Эрих Хэйниш /1880-1966/ , хожим нь монголчуудтай ажиллах болсон С.М.Вольф нар болон Германы Гадаад явдлын яамны Алс Дорнодын хэлтсийн ажилтнуудтай уулзаж байжээ.

\*Р.Жамц - доктор (Ph.D)

Дээрх зүтгэлтнүүд нь Германд очихдоо Германд худалдааны төлөөлөгч очуулах, Герман, Францад хүн сургах, Монголын аж ахуйн хөгжилд Германы тусламж авах, тэндээс мэргэжилтэн урьж авчирч ажиллуулах, худалдааг хөгжүүлэх талаар хэлэлцсэн түүх байдаг. Мөн БНМАУ Германд төлөөлөгчөө илгээх талаар хэдэн жилийн турш ярьсаны эцэст 1926 онд Дашсампилон, Хурлаг нарыг Германд илгээжээ. Тэд Герман улсаас аж үйлдвэрийн техник, технологи авах, мэргэжилтэн ажиллуулах, харилцан ашигтай худалдаа хийх, боловсон хүчин бэлтгэх, сургах асуудлаар тохиролцсон байна. Мөн энэ айлчлалын үр дүнд Берлинд тус улсын худалдааны төлөөлөгчийн газар ажиллах болсон байна. Энэ газрыг Дашсампилон тэргүүлэх болжээ. Монголын худалдааны төлөөлөгчийн газар 1929 оныг хүртэл ажиллажээ. Берлинд Монголын худалдааны төлөөлөгчдийн газар нээхийг Германы тал зөвшөөрсөн нь тэдний алс дорно луу хандах улс төрийн сонирхолтой холбоотой байсан юм гэж академич Ж.Болдбаатар бичсэн байдаг. 1928 оны 8-р сараас Берлин дэх Монголын худалдааны төлөөлөгчдийн газрын хийсэн хэлэлцээрийн дагуу Германы хэд хэдэн инженер, ажилчид Монголд ирж ажиллажээ. 1928 оны 5-р сард БНМАУ-ын Засгийн газар АЕГ пүүстэй гэрээ байгуулснаар 500 квт-ийн хүчин чадалтай цахилгаан станцыг 75000 ам.доллараар авах болжээ. Тэдгээр жилүүдэд БНМАУ-д Германы тусламжтайгаар тоосгоны завод, төмөр, цэмбэ, модны бага, дунд оврын үйлдвэрүүд бий болжээ. Мөн Германы тал Монголд зориулсан бараа үйлдвэрлэхийг зорьж туршиж байжээ. Тухайлбал, Германы “Kontintal” хэмээх бичгийн машины үйлдвэр монгол бичгийн машин хийж турших, Лейпцигт газрын зураг үйлдвэрлэх алхам хийж байсан байна. Монгол, Германы харилцаа нь эхэн үедээ бараа, түүхий эд солилцооны хүрээнд эргэлдэж байснаа сүүлдээ үйлдвэрлэлийн салбар уруу орох хандлагатай болсон байна. Германд анхны 25 монгол охид, хөвгүүдийг сургах болж, 1930 онд Халле хотод болсон Дэлхийн ажилчин тариачны хүүхдүүдийн хоёрдугаар уулзалтанд Монголоос хоёр охин, гурван хөвүүн оролцжээ. Энэ хүүхдүүд олон хурал цуглаанд оролцсоноос гадна Монголын пионерүүдийн зурагтай ил захидал зарж, орлогыг нь Саксоны пионерүүдийн Берлинд ирэх зардалд зориулж байсан түүхтэй.

1930 оны 7-р сарын 27-ны өдөр Берлин хот энэхүү уулзалтын билгэ тэмдэг болж байсан<sup>1</sup> зэргээс үзэхэд дээр дурдсан Монголын зүтгэлтнүүдийн Германтай ярьж тохирсон зүйл бодит байдлаар батлагдаж байна. 1921 оны Ардын Хувьсгалын дараах жилүүдэд Монголын дотоод, гадаад бодлогод тэр үеийн ЗХУ, Коминтерны зүгээс

хүчтэй нөлөөлөх болсон нь түүхийн үнэн байдал ч гэсэн Өрнөд Европ ялангуяа Германтай харилцаа холбоог аль болох өргөтгөх асуудал тухайн үеийн Монголын гадаад бодлогын хэмжээнд илэрхий тавигдаж байжээ. Тухайлбал 1924 онд Монголоос ЗХУ-д суух бүрэн эрхт төлөөлөгчөөр томилогдсон Б.Данзанд тэр үеийн ГЯЯ-наас өгсөн удирдамжинд ЗХУ-тай харилцаагаа хөгжүүлэхийн зэрэгцээ Герман зэрэг гадаад улсуудад биеэр очиж тэндхийн улс төрийн байдал, худалдааны харилцаа тогтоох боломж, Монголыг хэрхэн үзэж байгаа зэргийг судалж, монголч эрдэмтэдтэй уулзаж, ном хэвлэлээс нь олж ирүүлэх үүрэг өгч байсан байна.<sup>2</sup>

Мөн ЗХУ-аас бусад гадаад орнуудтай найрсаг харилцаа тогтоон хөгжүүлэх тухай заалт Москвад сууж байсан Монголын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын 1926 оны дүрэм болон ГЯЯ-ны 1927 оны дүрмэнд бас орсон байна. Гэвч тэр үеийн энэхүү бодлого бүрэн хэрэгжиж чадаагүй билээ. МАХН-ын ТХ-ны дарга Ц.Дамбадорж Өрнөд Европоос Франц, Германаар яваад буцаж ирээд “Известия Улан-Батор хото” сонины сурвалжлагчтай хийсэн ярилцлагадаа бодит байдлыг үндэс болгож нийт хүн төрөлхтөний үнэт зүйлсийн хувьд тэдгээр орны соёл иргэншлээс тунгааж тусгах зүйл их байгааг тэмдэглээд Монгол Улсын тусгаар тогтнон хүмүүжих явдал нь гадаад ертөнцөөс зожигрох биш нээлттэй байх явдал юм гэж байжээ.<sup>3</sup> Хэдий тэгсэн ч тэр үеийн ЗХУ-ын удирдлага, Коминтерний шууд оролцоотой 1927 онд хуралдсан МАХН-ын VII их хурал Ц.Дамбадорж, Н.Жадамбаа нарыг хөрөнгөтөн орнуудтай ойртож дотносох гэсэн “Баяжигтун” лозунг санаачилагчид үнэн чанартаа ЗХУ-аас хөндийрөх гэсэн гэж буруутган шүүмжлээд “Баруунтан” гэж шууд нэрлээд намын удирдлагаас гаргасан түүхтэй билээ. Энэхүү Их хурлын дараа “Баруунтныг илчлэх, намыг баруунтнаас цэвэрлэх” компаниг ажил өрнөж, үүнээс үүдэн Монголд байсан гадаадын иргэд, капиталыг шахан гаргаж эхэлсэн билээ. 1926 онд хуралдсан Улсын II Их хурлын илтгэлд тэмдэглэсэнээр Герман, Их Британи, Франц, АНУ зэрэг улсын харьяат иргэд 2700 орчим байжээ.<sup>4</sup> Түүнчлэн 1925 онд тоолсон тооллогоор Гандан, Богдын ордонг оруулалгүй тооцоход монголчуудын хашаа 2368, Орос, Хятад, Тувд, Англи, Франц, Европчуудын хашаа 1019 байжээ.<sup>5</sup> Тооллогын дараа эднийг бүртгээд хүчээр буцаажээ. 1929 онд зөвхөн Улаанбаатараас 4000 илүү иргэдийг хөөж явуулсан байна. Ц.Дамбадорж, Н.Жадамбаа нарын ярьж тохирсоны дагуу ирсэн Герман, Швед, Данийн мэргэжилтнүүд уригдан ирээд хөөгдөн буцаж, гадаадын сүүлчийн пүүсүүд хаагдсан билээ.

1921 оны Ардын хувьсгалын дараа тэр үеийн Монголын нам,

төрийн нэлээд зүтгэлтнүүд өөрийн орныг хөгжүүлэхэд гуравдагч өндөр хөгжилтэй орны тухайлбал, Германы дэмжлэгийг авахыг эрмэлзэж байжээ. Гэвч энэ нь дотоод, гадаадын тэмцэл, дарамттай тулгарч байсан юм. Германы дэмжлэгтэйгээр өөрийн улсын эдийн засгийг өөд татахын зэрэгцээ мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхийг тэд эрмэлзсэн байна. Ийнхүү 1926 онд Монголоос анх 25 хүүхэд Германд суралцахаар мордсон түүхтэй билээ. Тэд Берлин, Лейпциг зэрэг хотуудад айлаар амьдран сургуульд сурч байжээ. Төлбөрийг нь Монголын Засгийн газар хариуцаж, нэг оюутны жилийн дундаж зардал 1926 онд хуралдсан Улсын Ү Их хурлын илтгэлд тэмдэглэсэнээр 2230.21 төгрөг байсан ажээ. Тэр үед Германд анх суралцагсгалын нэг хожим нь Монгол Улсын гавьяат багш болсон Бавуу С.Наваан-Юндэнгийн гэргий Лхамсүрэнд дурсан ярихдаа :”Бид Германд явахдаа эхлээд “дож” машины кузовыг дэлгээд нуруу нуруугаа налан суугаад хөдөлж билээ. Шар хөв гэдэг газраас Алтанбулаг руу хоёр хоног морь, морин өртөөгөөр яваад тэндээсээ Сэлэнгээс Улаан-Үд хүртэл усан онгоцоор явав. Улаан-Үдээс галт тэргээр Москвад, цааш мөн галт тэргээр Ленинградад очиж, тэнд усан онгоц хүлээж долоо хоногсон. Тэр үед Ринчин Бямбаев, О.Намнандорж, киноны эрдэмтэн Гончиг нар бидэнд Ленинград хотыг үзүүлж, танилцуулсан. Ленинградад очоод анх нөгөө бэлтгэсэн европ хувцсаа өмслөө. Хожим нь нутагтаа ирээд Улаанбаатарт бид анх европ хувцсыг дэлгэрүүлсэн юм. Биднийг “цагаан захтнууд” гэж нэрлэдэг ч байлаа. Биднийг Умардыг зориход Амар сайд, Хатанбаатар ван, Цэвээнжамсранов нар үдэн гаргаж, билгийн сайхан үг сургаал хэлцгээж, их эрдэм сурахыг ерөөж байсан” гэжээ. Герман, Франц улсуудад суралцаж байсан сурагчдын монгол захиргаа байгуулагдаж даргаар нь Ишдорж гэдэг хүн ажиллаж байжээ.

Германд хүн сургах болсон энэхүү шийдвэр туйлын алсын хараатай байсан юм. Энэ тухай Германы эрдэмтэн Сергей Михайлович Вольф гэдэг хүн дурсан бичихдээ “1926-1930 онуудад Монголын 13-19 насны залуучуудын хэсгийг Герман/44/, Францад /5/ явуулж сургаж байсан нь БНМАУ-ын Өрнөдтэй тогтоосон анхны харилцаа байсан бөгөөд урьд өмнө нь үзэгдэж байгаагүй үйл явдал байв. Энэ нь зөвхөн соёлын төдийгүй бас улс төрийн шинжтэй байсан ажээ”<sup>6</sup> хэмээсэн байна.

Суралцагчдын дотор Монголын шинэ үеийн уран зохиолыг үндэслэгч Дашдоржийн Нацагдорж тэдгээрийн шилдэг төлөөлөгч байлаа. Тэрээр суралцахын зэрэгцээ Берлинд ажиллаж байсан Монголын худалдааны төлөөлөгчийн газар орчуулагч хийж байжээ. Эдгээр хүмүүсийн тоонд Ю.Наваан-Юндэн, Д.Намдаг, Намхайцэрэн, Юмбүү, Доржсүрэн, Монгол Улсын гавьяат багш Батсүх, гавьяат багш Бавуу

гээд хойч үедээ үлгэр дуурайлал болж нэрээ алдаршуулсан олон хүн байлаа. Германд суралцахаар явсан хүмүүсийн олонхи нь буцаж ирснийхээ дараа Монголын сэхээтнүүдийн сор болж байсан төдийгүй нийгмийн амьдралд үлэмж нааштай нөлөөлж байсан явдал үүнийг нотолж байгаа юм. Тэдгээрийн нэг их зохиолч Д.Нацагдоржийн бичсэн “Учиртай гурван толгой” дуурь нь зөвхөн Монголдоо төдийгүй дэлхийн соёлын санд оруулсан шилдэг бүтээлийн нэг билээ. “Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас хүний хүү эрдмийг өвөрлөн ирнэ” гэсэн түүний бичсэн алдарт мөрүүд дараа дараачийн үеийн нь оюутан залуучуудын уриа дуудлага болж мөнхөрсөн билээ. Тэр үеийн бас нэг алдартан Монголын жүжгийн нэрт зохиолч, төрийн хоёр удаагийн шагналт Д.Намдагийн “Шарай голын гурван хаан” жүжгийг монголчууд сайн мэднэ. Мөн тэр үеийн оюутны нэг байсан С.Наваан-Юндэн Монголын уншигчдыг Германы сонгодог зохиолчдын бүтээлтэй эх хэл дээрээ танилцах боломж олгосон нэртэй орчуулагч байлаа. Тэрээр олон жил Германы элчин сайдын яаманд орчуулагч хийж, бас ГЯЯ-нд ажиллаж байжээ. Мөн тэр цагийн бас нэгэн алдартны нэг Цэвэгийн бичсэн герман-монгол хэлний толь ч герман хэл сурахыг хүссэн хүн бүрийн ширээний ном болсон билээ. Монголын урлагийн алтан үеийнхний нэг урлагийн шавьяат зүтгэлтэн, нэрт зураач Намхайцэрэнг хүн бүхэн сайн мэднэ. Германд суралцагчдын нэг Юмбүү Монголын аж үйлдвэрийг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан, олон жил үйлдвэр удирдсан туршлагатай нэгэн байв. Монголын худалдааг хөгжүүлэх, хожим нь Берлинд худалдааны атташегаар ажиллаж байсан герман Доржсүрэн гэж нэрлэгдсэн энэ хүн бас л Германд анх суралцагчдын нэг байв.

Германд сурж байсан сурагчдыг эргэж тойрохоор 1927 онд Москвад Монголын элчин төлөөлөгчөөр ажиллаж байсан Ганжуурын Гүрсэд, хэлмэрч Бат-Очирын хамт очих үеэдээ Германы ГЯЯ-ны Дорно дахины асуудал хариуцсан ажилтнуудтай уулзаж өөрийн сурагч нараа захиж байжээ.<sup>7</sup> Түүнчлэн 1928 онд тэр үеийн Гэгээрлийн яамны сайд Эрдэнэбатхаан мөн Германд сурж байсан сурагчдаа эргэж иржээ. Гэвч Германд харгис засаг тогтсон, олон улсын байдал хурцалсан болон Коминтерний шахалтаар Герман, Францад сурч байсан оюутан сурагчдыг нутагт нь буцаах болсон юм. Ер нь тэр үед Герман, Францад суралцаж байсан оюутан, сурагчдыг буцаах болсон шалтгааны талаар түүхэнд тодорхой баримтууд үлдсэн билээ.

1929 оны 6-р сард гарын үсэг зурсан Монгол-Зөвлөлтийн харилцааны үндсэн зарчмуудыг тогтоосон хэлэлцээрт : “СССР нь Монголыг, Монгол нь СССР-ийг ийнхүү онцоор үзсэн лүгээ адил бусад

гадаад улсыг үзэх болсон нь хоёр этгээдийн уул бодлого зорилго лугаа үл нийцэх тул аливаа гадаад улсууд ба тэр улсуудын харьяат нарт тийнхүү онцоор үзэх явдлыг үл дэлгэрүүлэхийг хоёр этгээдээс батлана гээд БНМАУ нь зөвхөн ЗХУ-д бараа бүтээгдэхүүн экспортлож, зөвхөн ЗХУ-аас бараа бүтээгдэхүүн импортлох, ЗХУ-д үйлдвэрлэгдээгүй бараа бүтээгдэхүүнийг зөвхөн ЗХУ-ын нутгаар дамжуулан оруулж байх”-аар заажээ.<sup>8</sup> Энд Монголын зах зээлийг дангаар эзэгнэх гэсэн тэр үеийн ЗХУ-ын эдийн засгийн сонирголоос гадна Монголыг бусад орон, гадаад ертөнцөөс тусгаарлах гэсэн улс төрийн далд бодлого явагдаж байсан нь тодорхой байна.

Чухамхүү иймэрхүү улс төрийн бодлого тэр үед Герман, Францад сурч байсан сурагч оюутан залуучуудыг тойрч гараагүй бөгөөд тэд бүгд 1930 он гэхэд эх орондоо бүрмөсөн дуудагдаж ирсэн түүхтэй. Энд бас нэг ноцтой баримт гэвэл 1930 оны 03 дугаар сарын 31-нд Зөвлөлтийн Гадаад хэргийн ардын комиссариатын орлогч Л.М.Караханд Дотоод явдлын яамны улс төрийн газрын дарга Я.К.Березинээс явуулсан маш нууц бичигт: “Бидэнд байгаа мэдээгээр МАХН-ын эрх барьж байсан баруунтан удирдагчид хөрөнгөтөн оронд 25 сурагч илгээжээ. Үүнээс 5 нь Парисын эдийн засгийн сургуульд, 20 нь Германы янз бүрийн сургуулиудад сурдаг аж. Монголын боловсон хүчнийг бусад оронд сургах нь бидний хувьд хүлээн авч эс болох зүйл. Монголын засгийн газарт зохих хэлбэрээр даралт үзүүлж Франц, Германд сурч буй монголчуудыг татуулан, улмаар залуучуудыг тэдгээр орны сургуульд цаашид илгээжээс татгалзуулах нь чухал гэж Цэрэг, далайн цэргийн ардын комиссариатын орлогч Улшлихт үзэж байгааг танд мэдэгдье”<sup>9</sup> гэжээ.

### Ишлэл зүүлт

1. Baatar und der himmelblaue Chadag. Berlin 1976.S.66
2. ГХТА Ф 01 ш 1173.
3. Известия Улан-Батор хото 1926.10.01 №13.
4. БНМАУ-ын түүх. 3-р боть, УБ, 1969. 262-р тал
5. С.Идшинноров. Улаанбаатар хотын хураангуй түүх. УБ, 1994. 78-р тал
6. Friters. G.Onter Mongolia and uts international Position. London 1951. pp 300
7. С. Думбурай “Ганжуурын Гүрсэд” Залуучуудын үнэн, 1989.08.25 №94
8. Монгол-Зөвлөлтийн харилцаа. Баримт бичгүүдийн эмхтгэл 1921-1940, 1-р боть. УБ 1975, 125-р тал
9. Б.Баабар. XX зууны Монгол. УБ, 1996. 378-р тал.